



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2016 оны 4 дүгээр улирал, 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 267,319,910.00 (хоёр зуун жаран долоон сая гурван зуун арван есөн мянга есөн зуун арав) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2016 оны 4 дүгээр улирал, 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаярт дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2. Компанийн хөрөнгийг зохистой удирдах, авлага, өглөгийг бууруулах, харилцагчтай үлдэгдэл төлбөр тооцоог нийлж баталгаажуулах, найдваргүй болох эрсдэлтэй авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;

2.3. Борлуулалтын орлогыг цаг тухайд нь төвлөрүүлэх, авлагыг бууруулах, алданги тооцож байх зорилгоор төлбөр тооцооны бүртгэлийн программ хангамжтай болох;

2.4. Төрийн өмчийн байр талбайг түрээслүүлэхдээ Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын дагуу түрээслүүлэх, 2018 оноос түрээсийн төлбөрийн 30 хувийг төсөвт төвлөрүүлэх;

2.5. Албан ажлын хэрэгцээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см<sup>3</sup>-ээс дээш туулах чадвар өндөртэй жийп автомашин хэрэглэж байгааг таслан зогсоож, дуудлагын болон хөдөө ажлын хэрэгцээнд ашиглах;

2.6. Зориулалт бусаар ашиглаж байгаа 1 ширхэг туулах чадвар өндөртэй жийп автомашиныг дутагдалтай байгаа төрийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт төвлөрүүлэх;

2.7. Компанийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, удирдлагын чиг үүргийн давхардлыг арилгах.

0001983



2.8.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.Гаваа